

НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай ИНЕГ-ын даргын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр баталсан 08/20 дугаар удирдамжийн хүрээнд тус нэгжийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын Дотоод аудитын албаны аудитор Т.Саранчимэг, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ц.Цацрал нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааны үйл ажиллагаанд баримтлах дүрэм, журам, зааврын хэрэгжилт, дээд байгууллагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, тус нэгжийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт, дотоод хяналтын тогтолцоо, ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг хангаж байгаа эсэх, хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлд хийсэн ажил, гадны иргэн байгууллага, иргэнтэй хийсэн гэрээ хэлцэл, түүний эрх зүйн үндэслэл, хэрэгжилт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгаж, холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад нислэгийн зөвшөөрөл олгохтой холбоотой баримт бичиг орхигдсоноос архивт хадгалагдахгүй байна.

“Иргэний нисэхийн ерөнхий газар нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох” журамд хуваарьт нислэг үйлдэж байгаа гадаадын болон дотоодын агаарын тээвэрлэгчийн хуваарьт нислэг үйлдэх үед бүрдүүлэх баримт бичгийг тусгаагүй.

ATFMS системд 8 агаарын хөлгийн мэдээллийг давхардуулж оруулсан байна. Ингэснээр тооцооллын зөрүү үүсэх нөхцөл бүрдсэн байна.

Нийт хуваарьт нислэгийн зөвшөөрөл авсан 10 авиакомпанийг ATFMS системд гэрээт бус гэсэн ангилалд оруулсан, 2019 оноос өмнө хуваарьт нислэг үйлдэж байгаад хуваарьт нислэгийн зөвшөөрөл аваагүй 10 авиакомпанийн мэдээллийг системд шинэчлээгүй.

Хуваарьт нислэгийн зөвшөөрлийг програмд хуваарийн бус нислэгээр тэмдэглэсэн зөрчил гаргасан.

Дотоод хяналтын мэргэжилтэн хэсгүүдийн шалгалтаар илэрсэн үл нийцэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын тайланг буруу үнэлдэг, эргэн хяналт тавьдаггүй.

2019 онд хуваарьт нислэгийн зөвшөөрөл олгосон баримтаас 14 компанийн зөвшөөрлийн баримт дутуу, дугаарлалтыг алгасаж бүртгэсэн. 2019 оны хуваарьт нислэгийн өнгөрөлтийн тайланг хэн нэгтгэн гаргасан нь тодорхойгүй, албаны дарга хянаж баталгаажуулаагүй, архивын нэгжийг үдэж цэгцлээгүй байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар тус албанд 8 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА